Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГИЙН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар) | Гүйцэтгэл хувь | ХШҮ-ний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | | |
| **Стратегийн зорилт 1.1.Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх эрх зүйн орчинг сайжруулсан байна.** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.1.1. Хууль тогтоомж, бодлого, шийдвэр, журам, стандартыг боловсруулах, шинэчлэх, санал хүргүүлэх** | | **УТ** | **Шинэчлэн болон шинээр батлуулсан баримт бичгийн тоо (өссөн дүнгээр)** | **3** | **2** | **2** | **Ерөнхий сайдын дэвшүүлсэн “Чөлөөлье” санаачилгын хүрээнд төрийн албан хаагчийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан 3 журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлж батлуулан, тайлагнах давтамжийг 35.7 хувиар бууруулсан.** | **100** | **100** |
| 1.1.1.1 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал боловсруулах, үнэлгээний стандарт, (зарчим) боловсруулах | УТ | Боловсруулж батлуулсан баримт бичгийн тоо | - | 0 | 2 | Үнэлгээний стандарт боловсруулах ажлын хүрээнд Монголын Үнэлгээний Холбоо 40 гаруй үнэлгээний стандарт баримт бичгийг кодолж дүн шинжилгээ хийж байна. **Хүрсэн түвшин:** Судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд хэрэгжилт тооцох хугацаа болоогүй. | ХБ | ХБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.1.2 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан хөгжлийн бодлогын баримт бичгийн хяналт шинжилгээний дүнг тайлагнах цаглабарын зөрүүтэй байдалд санал хүргүүлэх | УТ | Саналын тоо | - | 1 | 1 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд 31 зүйл, заалт нэмэх, 30 гаруй заалтад өөрчлөлт оруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд 7 заалт шинээр нэмэх, 3 заалт хүчингүй болгох, 15 зүйл, заалтад өөрчлөлт оруулах саналыг боловсруулан УИХ-ын Тамгын газарт 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 01/187 дугаар албан бичгээр 1 удаа, цахимаар 1 удаа тус тус хүргүүлсэн. **Хүрсэн түвшин:** Саналын тоо 55 | 100 | 100 |
| **Стратегийн зорилт 1.2 Үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн тогтолцоог нэвтрүүлсэн байна.** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.2.1 Олон улсын үнэлгээний цогц систем /DME/ -ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах** | | **УТ, ГЗТ** | **Хэрэгжилтийн хувь** | **-** | **-** | **85** | **Хяналт шинжилгээ хийхэд AI ашиглах туршилтын ажил хийгдэж байна.** | **50** | **50** |
| 1.2.1.1 | Олон улсын үнэлгээний цогц систем (DME)-ийг хөгжүүлэх бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх | УТ, ГЗТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь (өссөн дүнгээр) | 44 | - | 85 | Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний үндэсний хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/49, А/18, 77 дугаар “Төлөвлөгөө, ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах | ХБ | ХБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухай” тушаал батлуулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг авч нэгтгэхээр ажиллаж байна. **Хүрсэн түвшин:** Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй. | | |
| 1.2.1.2 | Хяналт-шинжилгээ, үнэлгээний системийн ажлын даалгавар боловсруулах, системийг хөгжүүлэх бэлтгэл ажлыг хангах | УТ, ГЗТ | Батлуулсан ажлын даалгаврын тоо | - | 1 | - | Хяналт-шинжилгээ хийх дэд систем хөгжүүлэх ажлын хүрээнд “Блак Лабс” ХХК-тай санамж бичиг байгуулсан. Энэ хүрээнд хиймэл оюун ухааны модельд суурилсан үнэлгээний системийн туршилтын хувилбарыг турших, үнэлэх, туршилтын орчинд нэвтрүүлэх туршилтын ажлыг хийсэн бөгөөд эцсийн үр дүнг удирдлагад танилцуулсаны дагуу Газрын даргын 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/58 дугаар тушаалаар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх үйл ажиллагаанд хиймэл оюунд суурилсан тооцооллын аргачлал, дэвшилтэт технологийг туршин нэвтрүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, цаашид авах арга хэмжээний санал | 50 | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Үүний хүрээнд туршилтын ажил хийгдэж байна. **Хүрсэн түвшин:** Туршилтын ажлын тайлан-1 | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.2.2 Үндэсний болон салбарын бодлогод үнэлгээ хийх** | | **УТ, ГЗТ** | **Хөндлөнгийн болон дотоод үнэлгээний тайлангийн тоо** | **-** | **1** | **-** | **“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” бодлогын үнэлгээ хийх ажлын даалгавар батлагдаж, төлөвлөгөөний дагуу 8 аймгийн нийт 98 түлхүүр мэдээлэгчийн ярилцлагыг 220 төрийн албан хаагч, иргэн аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн.** | **63** | **63** |
| 1.2.2.1 | Улсын үнэлгээний чадавхын индексийг тогтоох, бодлогын үнэлгээ хийх | УТ, ГЗТ | Үнэлгээний тайлангийн тоо | - | - | 3 | 1/Үнэлгээний удирдах хорооны хурал 2026 оны 2 дугаар сарын 25-ны өдөр цахимаар хуралдаж, салбарын шинжээчийг сонгон шалгаруулсан.<br><br>2/“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” бодлогын үнэлгээний хийх ажлын хүрээнд бодлогын үнэлгээний хүрээнд мэдээлэл цуглуулах, судалгаа хийх удирдамжийн дагуу 8 аймагт ажиллаж нийт 98 түлхүүр мэдээлэгчийн ярилцлагыг 220 төрийн албан хаагч, иргэн, аж ахуйн нэгжийн | ХБ | ХБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөөлөлтэй хийсэн. Ярилцлагын үр дүнг нэгтгэх, өгөгдөлд боловсруулалтын ажил хийгдэж байна.<br>3/2026 оны Үнэлгээний нэгдсэн төлөвлөгөөнд туссан Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн 7.3.3, 7.3.3.2 дахь заалтуудад туссан дээрх сэдвийн хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг сайжруулах үр дүнд үнэлгээ хийх ажлын даалгавар боловсруулж байна. **Хүрсэн түвшин:** Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй. | | |
| 1.2.2.2 | Бодлого хэрэгжүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн бодлогын үнэлгээний төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих | УТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | - | 85 | "Бодлогын үнэлгээний 2026 оны нэгдсэн төлөвлөгөө"-ний төсөл боловсруулж, ЗГХХГ-ын 2026 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн 01/399 дугаартай албан бичгээр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаярт хүргүүлсний дагуу "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Үнэлгээ хийх журам"-ын 6.3 дахь хэсэгт заасны дагуу "Бодлогын үнэлгээний 2026 оны нэгдсэн төлөвлөгөө"-г | 63 | 63 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2026 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 188 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгсөн. **Хүрсэн түвшин:** Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-63 | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 1.2.3 Шийдвэр гаргалтад үнэлгээ, мониторингийн үр дүнг ашиглах механизм бий болгох хүрээнд Монгол Улсын хөгжлийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тодорхойлж танилцуулах** | | **Улсын төсөв** | **Хяналт-шинжилгээний тайлангийн тоо** | **-** | **2** | **14** | **Монгол Улсын хөгжлийн бодлогын хэрэгжилт, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг УИХ болон ЗГ-т танилцуулсан.** | **100** | **100** |
| 1.2.3.1 | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” хэрэгжилтийн явц үр дүнд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газар, | УТ | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | - | - | 1 | Хугацаа болоогүй. | ХБ | ХБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | УИХ-ын чуулганы хуралдаанд танилцуулах | | | | | | | | |
| 1.2.3.2 | Дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явц үр дүнд хяналт шинжилгээ хийж, дүнг Засгийн газар, | УТ | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо (өссөн дүнгээр) | 8 | 2 | 14 | 1/Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл энэ оноос хэрэгжиж эхлэх тул хяналт шинжилгээ хийгдээгүй болно.<br><br>2/ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, тайланг нэгтгэн боловсруулж, ЗГ-ын 2026 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулж, хурлаас гарсан шийдвэрийн дагуу УИХ-ын Тамгын газарт тайланг хүргүүлсэн бөгөөд 2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганд танилцуулсан.<br><br>3/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийж, төрийн байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хэрэгжилтийн түвшин, шалгуур үзүүлэлтийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | УИХ-ын Байнгын хороод, УИХ-ын чуулганы хуралдаанд танилцуулах | | | | | | хүрсэн түвшин, санхүүжилтийн гүйцэтгэлийг тодорхойлж, нэгдсэн тайлан, танилцуулга, холбогдох мэдээллийг эцэслэн боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайдад 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/117 дугаар албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ЗГ-ын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдааны тэмдэглэлээр үүрэг өгөгдсөн.<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг УИХ-ын Тамгын газар, Үндэсний аудитын газарт хуульд заасан хугацаанд хүргүүлж, улмаар тухайн байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу аудитын тайланд өгөх санал, тайлбар, нэмэлт мэдээллийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 05, УИХ-ын Тамгын газарт 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор албан бичгээр болон файлаар тус тус хүргүүлсэн. Тайланг УИХ-ын Тамгын газарт тайланг хүргүүлсэн бөгөөд 2026 оны | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 3 дугаар сарын 31-ний өдөр УИХ-ын нэгдсэн чуулганд танилцуулсан. | | |
| 1.2.3.3 | Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах | УТ | Танилцуулсан хяналт-шинжилгээний тайлангийн тоо | - | 1 | - | Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолоор "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын "Тайлагнах цаглавар"-т өөрчлөлт орж гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газарт танилцуулахаар тусгагдсан. | 100 | 100 |
| 1.2.3.4 | “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц болон 2026 оны улсын хөгжлийн жилийн | УТ | Хяналт хийсэн байгууллагын тоо<br>Хүргүүлсэн зөвлөмжийн тоо | -<br>- | -<br>- | 21<br>20 | ЗГХХГ-ын дарга бөгөөд ерөнхий хянан шалгагчийн баталсан 2026 оны 10 дугаартай удирдамжийн дагуу Хөвсгөл аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт шинжилгээ үнэлгээний 97, үр дүнгийн 189 шалгуур үзүүлэлт болон 110 төсөл, арга хэмжээний 119 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж шийдвэр, холбогдох баримт бичиг, | ХБ | ХБ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний гүйцэтгэлд газар дээрх хяналт хийх | | | | | | цахим систем, мэдээлэлтэй газар дээр нь очиж танилцаж, тухайн ажлыг хариуцсан 12 албан хаагчтай уулзаж, зөвлөгөө өгч ажилласан бөгөөд Бүс орон нутаг, бодлого төлөвлөлтийн газрын албан хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн хяналт шалгалтын газрын дарга, ахлах хянан шалгагчийн 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 02/09 дугаар удирдамжийн дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд газар дээрх хяналт-шинжилгээг хийж байна. Үр дүнг 6 дугаар сарын 30-нд танилцуулна. **Хүрсэн түвшин:** Хяналт хийсэн байгууллагын тоо-21 | | |
| 1.2.3.5 | Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх | УТ | Хяналт-шинжилгээ хийсэн арга хэмжээний тоо (өссөн дүнгээр) | 26513 | 27000 | - | 1/Аймаг, нийслэлийн таван жилийн үндсэн чиглэл энэ оноос хэрэгжиж эхлэх тул хяналт шинжилгээ хийгдээгүй болно.<br>2/21 аймаг, нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 2497 үр дүн, 5814 арга | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | арга хэмжээний төлөвлөгөө, аймаг, нийслэлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр, дүнд хяналт-шинжилгээ хийх | | | | | | хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ хийсэн.<br>3/21 Аймаг, нийслэлийн 2025 оны жилийн төлөвлөгөөний 2424 үр дүн, 3881 арга хэмжээ буюу нийт 6305 зүйл заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн.<br>**Хүрсэн түвшин:** Хяналт-шинжилгээ хийсэн арга хэмжээний тоо 38632 | | |
| 1.2.3.6 | Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийх | УТ | Хяналт-шинжилгээ хийсэн арга хэмжээний тоо (өссөн дүнгээр) | 5580 | 11160 | - | 1/Яам, агентлаг, аймаг, нийслэлийн нийт 49 байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний **7120** арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ хийсэн.<br>2/Яам, агентлаг, аймаг, нийслэлийн нийт 49 байгууллагын 2025 оны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийсэн.<br>**Хүрсэн түвшин:** Хяналт-шинжилгээ хийсэн арга хэмжээний тоо 12700 | 100 | 100 |
| 1.2.3.7 | Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын | УТ | Хяналт-шинжилгээний тайлангийн тоо (өссөн дүнгээр) | 38<br>38 | 83<br>- | -<br>83 | Яам, агентлаг, аймаг, нийслэлийн нийт 49 байгууллагын 2025 оны төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тамгын газрын 2025 оны үйл ажиллагааг үнэлж, тайланг нэгтгэн, нэгдсэн дүнг Засгийн газарт танилцуулах | | Зөвлөмжийн тоо (өссөн дүнгээр) | | | | нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, нэгдсэн тайлан танилцуулга, сайдын хэлэх үг, шийдвэрийн төсөл боловсруулан 2026 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 01/488 дугаартай албан бичгээр ЭЗХЯ болон ЗГХЭГ-т хүргүүлсэн. **Хүрсэн түвшин:** Хяналт-шинжилгээний тайлангийн тоо (өссөн дүнгээр)-87 | | |
| 1.2.3.8 | Хангалтгүй үнэлэгдсэн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд газар дээр нь хяналт хяналт хийж, төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ хийх чиглэлээр арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх | УТ | Хяналт хийсэн байгууллагын тоо /аймаг/ | - | 4 | 1 | ЗГХХГ-ын дарга бөгөөд ерөнхий хянан шалгагчийн баталсан 2026 оны 10 дугаартай удирдамжийн дагуу Хөвсгөл, Орхон, Булган аймгийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хяналт шинжилгээ үнэлгээний 97 үр дүнгийн 189 шалгуур үзүүлэлт болон 110 төсөл, арга хэмжээний 119 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж шийдвэр, холбогдох баримт бичиг, цахим систем, мэдээлэлтэй газар дээр нь очиж танилцаж, тухайн ажлыг хариуцсан 12 албан хаагчтай нэгжийн нэг бүрчлэн уулзаж, зөвлөгөөн өгч ажилласан бөгөөд Бүс орон нутаг, бодлого төлөвлөлтийн газрын албан | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн хяналт шалгалтын газрын дарга, ахлах хянан шалгагчийн 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 02/09 дугаар удирдамжийн дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд газар дээрх хяналт-шинжилгээг хийж байна. Үр дүнг 6 дугаар сарын 30-нд танилцуулна. **Хүрсэн түвшин:** Хяналт хийсэн байгууллагын тоо-4 | | |
| 1.2.3.9 | Үндэсний аудитын газраас бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | УТ | Хүргүүлсэн мэдээлэл (тоо) | - | 2 | - | 1/Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, хяналт-шинжилгээний тайланг УИХ-ын Тамгын газар, Үндэсний аудитын газарт хуульд заасан хугацаанд хүргүүлж, улмаар тухайн байгууллагуудаас ирүүлсэн албан бичгийн дагуу тайлбар, нэмэлт мэдээллүүдийг Үндэсний аудитын газарт 2026 оны 3 дугаар сарын 05-ны өдөр, УИХ-ын Тамгын газарт 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>2/Үндэсний аудитын газраас төлөвлөгөөний | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дагуу УХЖТ-ний гүйцэтгэлд аудит хийхтэй холбогдуулан тус газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу ЗГ-ын 2025 оны 43-р тогтоолын “Хяналт-шинжилгээ” хийх журамд заасан арга зүйн талаар сургалт хийсэн.<br><br>3/Мөн УХЖТ-нд хийсэн аудитын тайланд санал авахтай холбоотой асуудлаар 2 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт оролцож санал өгч, хамтран ажилласан.<br>**Хүрсэн түвшин:** Хүргүүлсэн мэдээллийн тоо-3 | | |
| 1.2.3.10 | Засгийн газар дахь хяналт шалгалтын 2025 оны ажлын ерөнхий дүн, иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, үр дүнг УИХ-д танилцуулах | УТ | Дүн-шинжилгээний тайлангийн тоо | - | 1 | - | ЗГХХГ-ын даргын 2026 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, салбарын хяналт шалгалтын 2025 оны гүйцэтгэлийн мэдээллийг 41 хяналтын чиглэлээр нь 11 яам, 3 агентлаг ирүүлснийг нэгтгэн 2026.02.13, 2026.02.25 өдрүүдэд салбарын хяналтын байцаагч нараас санал авч эцэслэн “Салбарын хяналт шалгалтын 2025 оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, нэгдсэн тайланг ЗГ-т | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танилцуулахаар хүргүүлсэн. **Хүрсэн түвшин:** Дүн-шинжилгээний тайлангийн тоо-1 | | |
| **Стратегийн зорилт 2.2 Хяналт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгааны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо нэмэгдсэн байна.** | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.2.1. Иргэд, олон нийтийн байгууллага, мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллах** | | **УТ** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж (Хувь)** | **-** | **100** | **-** | **"Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" бодлогын үнэлгээний багт дэмжлэг үзүүлэх техникийн багийн гишүүнээр 2 албан хаагч МҮХ-ны мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна.** | **100** | **100** |
| 2.2.1.1 | Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд төрийн болон бусад байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн, шинжээч оролцуулна. | УТ | Хамтран гүйцэтгэсэн хяналт шалгалтын тоо | - | 2 | - | Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2026 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А/64 дугаар удирдамжийн дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт чиг үүрэгт судалгаа шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмж боловсруулах ажлын хэсэгт хэлтсийн 1 албан хаагч, 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 02/09 дугаар удирдамжийн дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд газар дээрх | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хяналт-шинжилгээнд хэлтсийн 2 албан хаагч тус тус ажиллаж байна. Мөн “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах” бодлогын үнэлгээний техникийн багт дэмжлэг үзүүлэх техникийн багийн гишүүнээр 2 албан хаагч МҮХ-ны мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна. **Хүрсэн түвшин:** Хамтран гүйцэтгэсэн хяналт шалгалтын тоо-2 | | |
| 2.2.1.2 | Монголын Үнэлгээний холбоотой байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | УТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | - | 85 | Төлөвлөгөөг боловсруулж батлуулахаар ажиллаж байна. | ХБ | ХБ |
| 2.2.1.3 | Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх ажлыг зохион байгуулах | УТ | Судалгааны тайлан | - | 2 | - | Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгаа хийх ажлын хүрээнд ТСБТГ-тай хамтран ажилласан. Тус судалгааг улсын хэмжээнд зохион байгуулахад нийт 1309 төрийн албан хаагч хамрагдаж дундаж үзүүлэлтээр 70.9 хувьтай байгаа бөгөөд цалин хөлс, ажиллах орчин нөхцөл, ажлын ачаалал, гүйцэтгэлийн сайжруулах шаардлагатай гэсэн нэгдсэн дүгнэлт гарсан. | 100 | 80 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1.4 | Германы Хөгжлийн үнэлгээний байгууллагатай байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | УТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | - | 85 | Хугацаа болоогүй. | ХБ | ХБ |
| **Стратегийн зорилт 4.1. Цахим технологийн оновчтой шийдэлд тулгуурласан мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна.** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.1.3 Бодлогын хэрэгжилт, судалгаа, шинжилгээ, хяналт, үнэлгээний үр дүнг олон нийтэд нээлттэй танилцуулах, хэлэлцүүлэх цахим дэд бүтцийг бий болгох ажлын хүрээнд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим мэдээллийн санг хөгжүүлэх** | | **УТ** | **Үнэлгээ, мониторингийн системийн хөгжүүлэлтийн хувь** | **60** | **Суурь түвшнээс 10 % нэмэгдүүлэх** | **-** | **Системийн эхний хувилбар бэлэн болсон тухай үед системд тодорхой байгууллагуудын холбогдох баримт бичгийн биелэлтийг оруулж хяналт-шинжилгээ хийхээр шийдвэрлэсэн.** | **100** | **100** |
| 4.1.3.2 | Үнэлгээ, мониторингийн дэд систем хөгжүүлэх | УТ | Сайжруулалт хийсэн тоо (өссөн дүнгээр) | 3 | 4 | - | 1/ЗГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний new.unelgee.gov.mn цахим системийн ЗГАҮХ-ийг тайлагнах хэсэгт хяналт-шинжилгээний дүгнэлт хэсгийн “хэрэгжилт” цонхыг “ХШ-ний дүгнэлт” гэж, тайлбар хэсгийн доор “үр дүн гараагүй олон үр дүн хангалтгүй” гэсэн тодотгол | 100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэмж оруулах санал өгч, системд өөрчлүүлсэн.<br><br>2/Эдийн засаг хөгжлийн яамнаас хөгжүүлж буй бодлого төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем хөгжүүлэлтийн ажлын хүрээнд одоо хэрэгжиж буй журмын дагуу бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааг үнэлж байгаа процессын зураглалыг шинэчлэн гаргаж өгсөн. Мөн системийн эхний хувилбар бэлэн болсон тухай үед системд тодорхой байгууллагуудын холбогдох баримт бичгийн биелэлтийг оруулж хяналт-шинжилгээ хийхээр шийдвэрлэсэн. **Хүрсэн түвшин:** Сайжруулалт хийсэн тоо-4 | | |
| 4.1.3.3 | Шалгуур үзүүлэлтийн сан бүрдүүлэх | УТ | Санд оруулах шалгуур үзүүлэлтийн тоо | - | 200-аас доошгүй | - | Аймаг, нийслэлээс ирүүлсэн шалгуур үзүүлэлтийг салбар бүрээр нь ангилан нэгтгэж давхардлыг арилгаж 1051 болгосон, мөн салбарын яам олон улсын KPI чанарын үзүүлэлтийн судалгааг 11 салбарын 1345 | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгуур үзүүлэлтийг ангилж нэгтгэсэн.<br>**Хүрсэн түвшин:** Санд оруулах шалгуур үзүүлэлтийн тоо-2396 | | |
| **Стратегийн зорилт 4.2. Засгийн газрын харьяа байгууллагын албан хаагчдыг чадавхжуулж, нэгдсэн удирдлага, зохицуулалттай болсон байна.** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.2.1 Хяналт, үнэлгээ, мониторингийн болон бусад албан хаагчдыг үр дүнд суурилсан арга зүйгээр мэргэшүүлэх** | | **УТ** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | **-** | **100** | **-** | **Хяналт, үнэлгээ, мониторингийн болон бусад албан хаагчдыг үр дүнд суурилсан арга зүйгээр мэргэшүүлэх сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.** | **100** | **100** |
| 4.2.1.1 | Шинэчлэн баталсан гарын авлага, аргачлалаар яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, албан хаагчдад танилцуулах сургалт зохион байгуулах | УТ | Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо | - | 250-аас доошгүй | 250-аас доошгүй | 1/Авлигатай тэмцэх газарт (4 удаа), Үндэсний статистикийн хороо, Үндэсний аудитын газраас тус тус ирүүлсэн хүсэлтийн дагуу Хяналт-шинжилгээ хийх журам, түүнийг хэрэглэх арга зүйн талаар нийт 180 гаруй албан хаагчдад 6 удаагийн сургалт хийсэн.<br>2/2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр ХХААХҮЯ-ны албан хаагчдад “Бодлогын баримт бичиг, байгууллага, нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлагналтад анхаарах асуудал” сэдвээр сургалт орсон. Цахимаар болон | 100 | 100 |
| | | | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 3 | 2 | | | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танхимаар нийт 400 гаруй албан хаагчид оролцсон.<br>**Хүрсэн түвшин:** Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо 580, Зохион байгуулсан сургалтын тоо 4 | | |
| **Стратегийн зорилт 4.3. Мэдлэг, инновац, технологид суурилсан байгууллагын өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлсэн байна.** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 4.3.4 Байгууллагын гадаад, дотоод, хамтын ажиллагааг урт болон дунд хугацааны зорилго, зорилттой уялдуулан өргөжүүлэх** | | **УТ** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | **-** | **100** | **100** | **Байгууллагын гадаад, дотоод, хамтын ажиллагааг өргөжүүлэн хамтран ажиллаж байна.** | **100** | **100** |
| 4.3.4.1 | Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, төрийн бус, олон нийтийн байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах үйл ажиллагааг хариуцах | Улсын төсөв | Хамтран ажилласан тоо | 4 | 3 | 2 | 1/НҮБХХ-өөс 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Монгол Улсын Засгийн газрын хяналт, үнэлгээний чадавхыг бэхжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт 1 удаа, Удирдлагын академи болон Канад-Монголын Мерит төслөөс зохион байгуулсан “Үр дүнд” суурилсан үнэлгээ сэдэвт өглөөний уулзалт, хэлэлцүүлэгт 1 удаа, Канад–Монголын Мерит төслөөс Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулж буй Эмэгтэйчүүдийн манлайллын **"ХАМТДАА ТҮҮЧЭЭЛЬЕ"** хэлэлцүүлэг | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | т 1 удаа тус тус оролцож, санал солилцсон.<br><br>2/Японы Олон улсын хамтын ажиллагааны (Жайка) байгууллагатай уулзсан. Япон улсын бодлогын үнэлгээ туршлагыг суралцах боломжоор хангаж өгөхийг хүсэлт гаргасан.<br><br>3/2026 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Дэлхийн банкны Глобал үнэлгээний санаачилга (GEI)-ын төв азийн орнуудыг хариуцсан түншлэгч CLEAR PCA-ийн захиралтай Хяналт-шинжилгээ, үнэлгээ, төлөвлөлт, төсөвлөлтийн тогтолцооны хүрээнд хамтран ажиллах боломжуудын талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулж, хамтран ажиллах санамж бичиг болон сонирхол илэрхийлэх бичгийн төслийг өгсөн загварын дагуу боловсруулж, цахимаар хүргүүлсэн.<br><br>4/ЗГХХГ-аас төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх, бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг боловсронгуй болгох, | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох зорилгоор НҮБ-ын Суурин зохицуулагчийн газартай санал солилцсон бөгөөд Хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд хиймэл оюун ухааныг ашиглах боломж, чиг хандлага" сэдэвт илтгэлийн хүрээнд асуулт, хариулт, хэлэлцүүлэг өрнүүлсэн. Цаашид төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулах, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх ажлуудыг бодитой болгох хамтын ажиллагааг эхлүүлэх санал солилцсон. **Хүрсэн түвшин:** Хамтран ажилласан тоо-4 | | |
| **5.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх** | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 5.1.Нэгжийн гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх** | | **УТ** | **Төлөвлөгөөний биелэлт (хувь)** | **100** | **100** | **-** | **Нэгжийн гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.** | **100** | **100** |
| 5.1.1 | Газрын болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж | УТ | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (хувь) | 90 | 91-ээс доошгүй | 91-ээс доошгүй | Үнэлгээ, мониторингийн газар, нэгж, албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 217 дугаар | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | батлуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж, үр дүнг үнэлж дүгнүүлэх | | | | | | тогтоол, төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан журам, аргачлалын дагуу боловсруулж, удирдлагаар батлуулж, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн систем (pm.hrs.gov.mn)-д байршуулан биелэлтийг гарган, тогтоосон хугацаанд Тамгын газарт хүргүүлсэн. **Хүрсэн түвшин:** 100 | | |
| 5.1.2 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивлаж, архивд хүлээлгэн өгөх | УТ | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт (хувь) | 100 | 100 | 100 | Тайлант хугацаанд тус газарт нийт **154** албан бичиг хүлээн авснаас **17** албан бичиг хариутай бичиг байсан ба холбогдох асуудлыг судалж шийдвэрлэн, хариуг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлэн ажилласан. Мөн бусад нэгжүүдээс ирүүлсэн **20** дотоод албан бичиг хүлээн авсан бөгөөд холбогдох асуудлыг судалж шийдвэрлэн, хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.<br><br>2025 оны хариутай, хариугүй албан бичиг болон бусад баримт бичгүүдийг | 100 | 100 |
| | | | Хугацаандаа архивд хүлээлгэн өгсөн эсэх (тийм-1, үгүй-0) | - | 1 | - | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | архивын нэгж үүсгэн архивд бүрэн хүлээлгэж өгсөн болно. | | |
| 5.1.3 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан үүргийг хэрэгжүүлэх | УТ | ХАСУМ, ХОМ-тэй холбоотой зөрчил гарсан эсэх (тийм-1, үгүй-0) | - | 0 | 0 | Тус газрын албан хаагчид ХАСХОМ хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлж, баталгаажуулсан. | 100 | 100 |
| | | | Шаардлагатай тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан эсэх (тийм-1, үгүй-0) | - | 1 | 1 | | | 100 |
| 5.1.4 | Газрын албан хаагчдын мэдлэг, ур чадварын түвшин, эрэлт хэрэгцээнд үндэслэн холбогдох чиглэлээр сургалт, семинарт хамруулж, мэргэшүүлэх | УТ | Мэдлэг чадвараа дээшлүүлсэн албан хаагчдын тоо /давхардсан тоогоор/ | 10 | 5 | 5 | 1/Төрийн байгууллага дахь AI хэрэглээ" сэдэвт сургалт, Төрийн байгууллага дахь AI хэрэглээ" сэдэвт сургалтад газрын 4 албан хаагч хамрагдсан. | 100 | 100 |
| | | | Албан хаагчдын ажлын бүтээмжид гарсан зэрэг өөрчлөлт | - | - | - | 2/Канад–Монголын Мерит төсөл Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Удирдлагын академитай хамтран 2026 оны 2 дугаар сарын 2-ны өдрөөс 6-ны өдрүүдэд, мөн Увс аймагт зохион байгуулсан 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс 24-ны өдрүүдэд зохион | | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулсан “Үр дүнд суурилсан удирдлага”-ын сургалтад газрын нийт 5 албан хаагч тус тус хамрагдсан.<br><br>3/Монголын үнэлгээний холбоо, Германы хөгжлийн институтийн хамтран зохион байгуулсан “Үнэлгээний сургагч багш бэлтгэх” сертификаттай сургалтад газрын 2 албан хаагч хамрагдаж амжилттай суралцсан.<br><br>4/Байгууллагаас зохион байгуулсан “Эрсдэлийн удирдлагын тогтолцоо”, “Эрсдэл хариуцагч албан хаагчдыг чадавхжуулах” сургалтад газрын 8 албан хаагч хамрагдаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.<br><br>5/Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч хамрагдан суралцаж, 2026 оны 02 дугаар сард төгссөн.<br><br>6/ХБНГУ-ын ЭЗХАХЯ-ны харьяа Хөгжлийн үнэлгээний байгууллага, ЗГХХГ, монголын Үнэлгээний холбоотой хамтран зохион байгуулсан олон улсын IV дэх удаагийн зуны үнэлгээний сургалт “4$^{th}$ summer evaluation | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Bootcamp”-д 2026 оны 6 сарын 07-ны өдрөөс 11-ны өдрүүдэд хэлтсийн 1 албан хаагч оролцож сертификат авсан.<br><br>7/2026 оны 6 дугаар сарын 16-ны өдөр “Үнэлгээ хийх зарим аргачлал, Улсын үнэлгээний чадавхын индексийн хэрэглээ” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Мөн Германы Хөгжлийн үнэлгээний байгууллага, Монголын үнэлгээний холбоотой хамтран INCE индексийн хэрэглээ, MESA арга хэрэгслийг танилцуулж хэлэлцсэн бөгөөд сургалтад 17 албан хаагчийг хамрагдсан.<br><br>8/Монгол, Тайландын хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Бангкок хотноо 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс 19-ний өдрийн хооронд зохиогдсон “Хиймэл оюун болон өгөгдлийн шинжлэх ухаан” сэдэвт сургалтад газрын 1 албан хаагч хамрагдаж сертификат авсан.<br><br>**Хүрсэн түвшин:** Мэдлэг чадвараа дээшлүүлсэн албан хаагчдын тоо-39 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.5 | Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах | УТ | Өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | 98 | 100 | 100 | 1/Байгууллагын даргын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/20, А/22 дугаар тушаалаар өгсөн үүргийн дагуу ЗГХХГ/20260203033, ЗГХХГ/20260202038 тендер шалгаруулалтын кодтой бараа, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий тендерийн хорооны нарийн бичгийн даргаар газрын 1 албан хаагч ажиллаж 2 тендерийн баримт бичгийг боловсруулсан.<br>2/Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны харьяа, хараат бус Хөгжлийн үнэлгээний байгууллага (DEval)-тай уулзалтыг зохион байгуулсан.<br>3/Газрын даргаас өгсөн чиглэлийн дагуу “Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлагналтад анхаарах асуудал” сэдэвт танилцуулга мэдээлэл бэлтгэн контент хийсэн.<br>4/Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Авлигатай тэнцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | kutulbur.ioas.mn системд оруулан тайлагнасан.<br><br>5/Засгийн газрын харьяа төрийн болон нутгийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсэгт газрын 3 албан хаагч томилогдсон. Энэ хүрээнд төрийн захиргааны төв байгууллага, нутгийн захиргааны байгууллагын нийтлэг чиг үүргийн хууль эрх зүйн хүрээн дэх бүтцийн судалгаа, мөн хариуцсан байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийсэн бөгөөд тус ажлын хэсэг нь үр дүнгээ 2026 оны 01 дүгээр сард танилцуулсан.<br><br>6/Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн төвийн бүсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан зөвлөхийг хүлээн авч уулзалт зохион байгуулсан.<br><br>7/Байгууллагын даргын 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/57 дугаар тушаалаар байгууллагын “Эцэг, эхийн зөвлөл”-д нарийн бичгийн даргаар газрын 1 албан хаагч | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | томилогдон ажиллаж байна.<br><br>8/Байгууллагын даргын 2026 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/56 дугаар тушаалаар байгууллагын эд хөрөнгийн тооллогын комисст газрын 1 албан хаагч гишүүнээр томилогдон ажиллаж байна.<br><br>9/2026 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Үндэсний Аудитын газар, УИХ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Эдийн засаг, хөгжлийн яам, Иргэний нийгмийн байгууллагууд, Хөгжлийн түншүүд, Монгол дахь НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн газар болон НҮБХХ-ийн Бангкок дахь Бүсийн төвийн шинжээчдээс бүрдсэн “Төрийн хяналт шинжилгээ, үнэлгээний чадавхын өнөөгийн хэрэгцээ, эрэлт” сэдэвт олон талт оролцогчдын хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br><br>10/Хяналт хэрэгжүүлэх газрын удирдлагууд яам | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | болон агентлагуудтай уулзалт зохион байгуулах хүрээнд 16 яам болон холбогдох агентлагуудын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх явцад гарсан алдаа дутагдал, анхаарах асуудлаар мэдээлэл бэлтгэж танилцуулсан.<br><br>11/Газрын даргаас өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, үр дүн, албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүй зэрэг нийт 19 мэдээллийн Social monitoring хийсэн.<br><br>12/Засгийн газрын хяналтын тухай хуульд заасан чиг үүргийн дагуу хийсэн 2025 оны хяналт шалгалтын ерөнхий дүнг нэгтгэн, нэгдсэн танилцуулгыг бэлтгэсэн.<br><br>13/Ерөнхий сайдын дэвшүүлсэн “Чөлөөлье” санаачилгын хүрээнд төрийн албан хаагчийн ажлын ачааллыг бууруулах зорилгоор ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан 3 журамд нэмэлт | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өөрчлөлт оруулж, тайлагнах давтамжийг 35.7 хувиар бууруулсан.<br><br>14/Үнэлгээ, мониторингийн газрын процессын зураглал хийж, ТСБТГ-ын албан хаагчид хүргүүлсэн.<br><br>15/Хяналт хэрэгжүүлэх газраас 21 аймгийн Засаг даргын тамгын газрын дарга нартай цахим уулзалт зохион байгуулсан бөгөөд тус уулзалтад 21 аймгийн нийт 182 албан хаагч хамруулсан.<br><br>16/Монгол Улсын Ерөнхий сайдын шуурхай үүрэг, даалгаврын хэрэгжилтийн хүрээнд Засгийн газрын тогтоол 3, Ерөнхий сайдын албан даалгавар 6, хуралдааны тэмдэглэл 5 нийт 14 шийдвэрийн 170 үүрэг даалгаврын хэрэгжилтэд 7 хоног бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулан ажиллаж байна.<br><br>17/Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлтүүдийг тухайн арга хэмжээтэй уялдсан эсэх, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | арга хэмжээ хоорондын давхардал байгаа эсэх, мөн хэмжих нэгжийг оновчтой сонгосон эсэхийг нягталж, сайжруулан саналыг хүргүүлсэн.<br>18/Ерөнхий сайдаас өгсөн үүрэг, даалгаврын холбогдох заалтын биелэлтийг бүрэн хэрэгжүүлж дуусах хугацааны төлөвлөгөөг загвар хүснэгтийн дагуу Яам, агентлагаар нэгтгэн боловсруулсан.<br>19/2026 оны үнэлгээний нэгдсэн төлөвлөгөөнд туссан Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн 7.3.3.2 дахь заалтуудад Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг сайжруулах үнэлгээний ажлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2025, 2026 оны төсвийн тухай хуулийн хоорондын нийцлэлийг харьцуулан судалж байна. | | |
| 5.1.6 | Газрын болзошгүй эрсдэлийн илрүүлэх, бүртгэх | УТ | Илрүүлсэн эрсдэлийн тоо | - | 5 | 5 | “Байгууллагын албан хаагчдын эрсдэлийн удирдлагын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, чиг үүргийг таниулах сургалт”ад хамрагдаж газрын болон | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагын болзошгүй эрсдэлийн талаар холбогдох 7 санал гаргаж хүргүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:** Илрүүлсэн эрсдэлийн тоо 7 | | |
| НИЙТ ҮНЭЛГЭЭ /ХУВЬ/ | | | | | | | | | 93.2 |

**ТАЙЛАНГ ҮНЭЛСЭН:**

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА .................................................... П.БАТБААТАР

*Тэмдэг*

2026.6.10
*(огноо)*

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**

ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ.................................................... Р.ДЭЖИД

2026.06.16.
*(огноо)*

**ТАЙЛАГНАСАН:**

ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ .................................................... Б.ЗОЛБОО

2026.06.16
*(огноо)*